

Үе үеийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын боловсролын салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөлт боловсруулж батлуулах, боловсролын үйлчилгээг иргэдэд тасралтгүй, чанартай хүргэхэд шаардагдах эрх зүй, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэх, хэрэгжилтийг бодлогын удирдамжаар хангах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн.

Хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа өнөөгийн нийгэмд боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлагад нийцүүлэн өөрийн орны боловсролын салбарыг хөгжүүлэх бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиг үүргийг өнөөгийн Боловсрол, шинжлэх ухааны яам хэрэгжүүлж байна.

Өнөөдөр тогтвортой хөгжилд хүргэхэд шаардлагатай дэлхийн хэмжээний томоохон хувирган өөрчлөлтийг бий болгоход бодлого боловсруулагч байгууллага онцгой үүрэг хариуцлага хүлээдэг. ТХБ-ыг дэмжсэн бодлогыг нарийвчлан уялдуулах нь зөвхөн боловсролын салбарт төдийгүй тогтвортой хөгжилд оролцдог бүх салбарт хамаатай юм.

*Тогтвортой хөгжлийн боловсролын “Бодлогыг нарийвчлан уялдуулах” тэргүүлэх чиглэлд тусгагдсанаар:*

### БИД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Тогтвортой хөгжлийн боловсролыг боловсрол ба тогтвортой хөгжилтэй холбоотой дэлхий нийтийн, бүс нутгийн, үндэсний болон орон нутгийн бодлогуудад нэгдмэл байдлаар тусгасан байх ёстой.

- ТХЗ-уудад бүрэн нийцсэн суралцахуйн зорилтуудыг тодорхойлох ёстой.  
ТХБ-ыг боловсролын хөгжлийн бодлогод тухайлбал:
  - суралцахуйн орчин,
  - сургалтын хөтөлбөр,
  - багшийн боловсрол,
  - суралцагчийн үнэлгээ зэрэгт интеграцчилж, ингэхдээ жендэрийн тэгш байдлыг хангах талаас нь үргэлж бодож анхаарч байх ёстой.
- Боловсролын байгууллага суралцагчдын чадавхыг үнэлэхийн тулд боловсролын чанарыг баталгаажуулах шалгуурт ТХБ-ыг суурь болгон шигтгэж өгөх ёстой.
- Албан, албан бус боловсрол ба суралцахуй хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх бодлого боловсруулж байх ёстой. тухайлбал, олон нийтийн оролцоотой, тогтвортой байдлын асуудлуудыг шийдвэрлэх төсөлд-суурилсан суралцахуйг дэмжих бодлогын арга хэмжээ
- ТХЗ-уудыг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн бүх бодлогод ТХБ-ыг интеграцчилах ёстой. Жишээлбэл, уур амьсгалын өөрчлөлтийг багасгах зорилго нь бүх бодлогод ТХБ чухал байр суурь эзлэх ёстой.

### ҮНДЭСНИЙ БОДЛОГО, ЧИГЛЭЛД ХЭРХЭН УЯЛДСАН БЭ?

Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах нь “Тогтвортой хөгжлийн зорилго” 4-ийн үндсэн зорилт бөгөөд Монгол Улс уг зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого, стратегийг үндэсний хөгжлийн бодлогодоо тодорхойлон хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- I. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцооны шинэчлэл хийхээр зорьж байна.
- II. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд:

- сургалтын хөтөлбөрийг монголын түүх, эх хэл, зан заншил, эх оронч үзэл хандлага, үндэсний өв уламжлалын агуулгаар баяжуулах;
- Бүх нийтийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсний тухай боловсрол олгох; сургалтын цахим платформ хөгжүүлэх;
- Боловсролын чанарыг олон улсад үнэлүүлэх бодлогыг төрөөс баримталж байна.

## ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ ХҮРЭЭНД ТХБ-II ТӨСЛИЙН ХУВЬ НЭМЭР ЮУ БАЙВ?

Бодлогыг нарийвчлан уялдуулах тэргүүлэх чиглэлийн хүрээнд Тогтвортой хөгжлийн боловсролын II төслийн оруулж буй хувь нэмрийг дараах байдлаар тодорхойлж байна.

1. Тогтвортой хөгжлийн боловсролын II төслийн ажлын нэг хэсэг “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл (2024)”-ийг дэмжихэд чиглэж, “Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлал, агуулга, арга зүйг сургалтын хөтөлбөрт тусгах зөвлөмж” боловсруулсан. Өөрөөр хэлбэл, төслийн хүрээнд сургалтын хөтөлбөрийн дараагийн шинэчлэлд дэлхий нийтийн чиг хандлага болсон ТХБ-ын үзэл баримтлалд суурилсан “СБААХ-ын нэг бүрэлдэхүүн хэсэг болсон сургалтын хөтөлбөрийн хөгжүүлэлт /Байгшлахуй, суралцахуйг хувирган өөрчлөх зарчим, арга аргачлалын загвар болохуйц сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд зориулсан багц хэрэгсэл/гарын авлага бэлтгэж өгсөн нь бүх шатны боловсролын хөгжилд бодитой хувь нэмэр оруулах болно гэж үзэж байна.
2. Төсөл хэрэгжих хугацаанд боловсруулсан “Сургууль бүхлээрээ ажиллах арга хандлага (СБААХ) гэсэн аргачлал” нь сургуулийн өөрийн үнэлгээнд чухал хэрэгсэл болсон. Энэхүү аргачлалын дагуу сургуулиуд нөхцөл байдлаа цогцоор нь, олон талаас нь үнэлж, сургуулийн орчинд нэн даруй шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудыг сургуулийн хамт олон, оролцогч талуудын оролцоотойгоор тодорхойлно. Боловсролын салбарт гарч буй бодлогын нэг өөрчлөлт бол сургууль санхүүгийн хувьд хагас бие даасан хэлбэртэй болж, сургуулийн зөвлөл төсөв, санхүү, хөрөнгө оруулалттай холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх болж байгаа. Тэгэхээр сургуулийн өөрийн үнэлгээгээр илэрсэн асуудлуудыг шийдэх боломжтой болж байна гэсэн үг.
3. “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн хүрээнд анх удаагаа “Боловсролын сэтгэл зүйч”-ийг бэлтгэж 2021-2022 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуульд ажиллуулж эхэлсэн нь ТХБ-ын суурь зорилтуудыг хангахад ихээхэн нөлөө үзүүлсэн ажил болсон. Өнөөдрийн байдлаар 151 мэргэшсэн сэтгэл зүйч ерөнхий боловсролын сургуульд ажиллаж, суралцагчдын сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх, зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулж байгаа нь ТХ-ийн төлөөх санал санаачилгыг бүх талаар дэмжиж байгааг онцлон тэмдэглэж байна.
4. БШУЯ-наас ЕБС-д ажиллах “боловсролын сэтгэл зүйч” бэлтгэх санаачилгыг “Тогтвортой хөгжлийн боловсрол-II” төслийн хүрээнд туршин хэрэгжүүлсний үр дүнд нийт **73919** хүнд давхардсан тоогоор тусламж үйлчилгээ үзүүлсэнээс **52937** сурагч, **13447** эцэг эх, **7535** багш ажилтан байгаа онцлохын зэрэгцээ боловсролын сэтгэл зүйчидтэй хамт ментор сэтгэл зүйчдийг ажиллуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, кейс илрүүлэлт, холбон зуучлах үйл ажиллагаанд чиглүүлэг өгч, **онцгой кейс 74-ийг** илрүүлж холбон зуучлах үйл ажиллагааг явуулснаар эрсдэлт үйлдэл болохоос урьдчилан сэргийлж, таслан зогсоож чадсан.

Монгол Улсад тогтвортой хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр багагүй ажил хийж байгаа боловч хэрэгжилт, үр дүн хангалттай биш. Боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдал, багш, ажиллагсдын хүйсийн харьцаа алдагдсан, ерөнхий боловсролд хөвгүүдийн сурлагын амжилт анхаарал татахуйц сул байгаа тул хэрэгжилтийг хангах байгууллага, хэрэгжилтийг удирдах үйл явц, засаглалын асуудалд онцгой анхаарал хандуулах чухал байна.